

<http://www.today.mn/p/25042>

Монгол, Австрали улсын хооронд дипломат харилцаа тогтоогоод 45 жил боллоо
2017 02 сар 06

Австрали, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой энэ онд тохиож байна. 1972 оны есдүгээр сарын 15-нд Австралийн Ерөнхий сайд агсан Гооф Витлам Монгол Улстай дипломат харилцаа тогтоох баримт бичигт гарын үсэг зурж байжээ. Харин 1990 оноос Монгол Улс либерал ардчилал, чөлөөт эдийн засгийн тогтолцоог сонгосноос хойш хоёр улсын харилцаа өргөжиж, олон салбарт хамтран ажиллах болсон.

Энэ тухай Австрали улсаас Монгол улсад суугаа элчих сайд Жон Лангтри хэлэхдээ “Манай хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой энэ жил тохиож байна. Австрали Улсаас Монгол Улсад суух анхны Элчин сайдын хувьд Монгол түнш нартайгаа анх удаа Австралийн өдрийг тэмдэглэх гэж буйдаа баяртай байна” гэсэн юм.

Мөн тэрээр цааш ярихдаа “Австрали Улс Монгол Улсад жил бүр 10 сая австрали долларын хөгжлийн тусламж үзүүлж байна. 1993 оноос хойш 500 орчим монголчууд тус улсын ЗГ-ын тэтгэлгээр Австралид дээд боловсрол эзэмшиж, эрдэм мэдлэгээ дээшлүүлжээ. Байгалийн баялгаа түшиглэн улс орноо хөгжүүлэхэд өндөр чанартай, гадаадын хөрөнгө оруулалт татан, удирдах тал дээр Австрали Улс арвин туршлагатай. Энэ талаар “Австрали ч, Монгол Улс ч эдийн засгийн хүндрэлтэй тулгараад байна. Монгол Улс Олон улсын валютын сантай нягт хамтран, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхээр идэвхийлэн ажиллаж байгааг харахад таатай байна. Энэ хүнд цаг үед манай хоёр орон биднийг нэгтгэж ирсэн, мөн улс төр, эдийн засаг, иргэний эрх, эрх чөлөөг хангах суурь болсон либерал ардчиллын зарчмаа баримтлах нь чухал” гэдгийг онцоллоо.

Харин сүүлийн жилүүдэд Австрали улс уул уурхайн салбарын мэдлэг туршлагаасаа Монгол Улстай хуваалцаж байна. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах чиглэлд түншлэн, Монгол Улсад мэргэжлийн боловсрол, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих, нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, уул уурхайн салбарын засаглалд тэргүүн туршлага нэвтрүүлэх зэргээр хамтран ажиллаж байгаа юм.